



НИЙСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/51

Улаанбаатар хот

Жагсаалт, журам батлах тухай

Монгол Улсын "Төсвийн тухай хууль"-ийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 "Эрүүл мэндийн тухай хууль"-ийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.4, 24.5, "Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль"-ийн 21 дүгээр зүйлийн 21.5, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/228 дугаар тушаал, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 49/А/118 дугаар тушаал, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/19 дугаар тушаалаар батлагдсан "Амаржих газрын дүрэм"-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.2.6 дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус амаржих газрын "Төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ыг нэгдүгээр, "Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт, тариф"-ийг хоёрдугаар, "Нөхцөл сайжруулсан орны тоо, мөрдөх тариф"-ийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчдэд чанартай, тэгш, хүртээмжтэй байхаар зохион байгуулж ажиллахыг албадын дарга, тасгийн эрхлэгчид, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга (Д.Наранцацралт), Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны дарга (С.Мөнхзул) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогыг төсөвт төвлөрүүлэн, биелэлтийг улирал тутам тооцож ажиллахыг Дотоод хяналт, шалгалт хариуцсан ажилтан (Т.Хосбаяр)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.БАТСАЙХАН



Нийслэлийн Өргөө амаржих газрын
даргын 2024 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийн
А/С тоот тушаалын нэгдүгээр хавсралт

ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ
Нэг. Нийтлэг үндэслэл



- 1.1 Энэхүү журмаар Нийслэлийн Өргөө амаржих газраас эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж үйлчилгээний багцад ороогүй зарим тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчдийн хүсэлтийн дагуу нэмэлтээр үзүүлэх, эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэнд төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлснээс бий болсон орлогыг зарцуулахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Төлбөртэй тусламж үйлчилгээ гэдэгт энэ журмын хавсралтад заасан тусламж үйлчилгээ хамаарна.
- 1.3 Төлбөртэй тусламж үйлчилгээний төлбөрийн хэмжээг байгууллагын вэб сайт, мэдээллийн самбар хүлээлгийн танхим, кассын дэргэд иргэнд харагдахуйц байрлуулна.

**Хоёр. Төлбөртэй тусламж, үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлага,
орлого бүртгэх, орлогын зарцуулалт**

- 2.1 Төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогыг амаржих газрын кассаар дамжуулан авч, үндсэн үйл ажиллагааны орлогын бүртгэлд бүртгэн, санхүүгийн програмыг ашиглан төрийн сан дах амаржих газрын төсвийн харилцах дансанд төвлөрүүлнэ.
- 2.2 Үйлчлүүлэгчид төлбөр төлсөн баримт, и-баримтыг заавал олгох бөгөөд амаржих газрын нэр, иргэнд үзүүлсэн тусламж, үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээ, огноог тэмдэглэсэн байна.
- 2.3 Төлбөртэй орны төлбөрийг тухайн тасгийн арга зүйч эх баригч, арга зүйч сувилагч хариуцан үйлчлүүлэгчээр байгууллагын кассанд төлүүлэн төлбөрийн баримтын нэг хувийг өвчтний түүхэнд хавсаргана.
- 2.4 Төлбөртэй өрөөнд хэвтэн эмчлүүлснээр үйлчлүүлэгч бусад ижил төрлийн тусламж, үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчээс илүү эмчилгээ, оношилгоо, сувилгаа авах, хөнгөлөлт эдлэх үндэслэл болохгүй.
- 2.5 Үйлчлүүлэгч өөрийн хүсэлтээр төлбөртэй тусламж, үйлчилгээг зогсоох санал гаргавал тухайн тусламж, үйлчилгээг зогсоох хүртлэх үеийн төлбөрийг тооцож, үлдэгдэл төлбөрийг ямар нэгэн шимтгэл, хураамжгүйгээр буцаан олгож баримтжуулна.
- 2.6 Амаржих газрын эмэгтэйчүүдийн тасагт хэвтэж, умайг умайн дайврын хамт бүхэлд нь авах мэс засал хийлгэсэн үйлчлүүлэгч өөрийн хүсэлтээр нугасны гадна хөндийн өвдөлт намдаах эмчилгээг сонгосон бол зөвшөөрлийн маягт бөглөн төлбөрийг мэдээгүйжүүлэгч сувилагч хариуцан үйлчлүүлэгчээр байгууллагын кассанд төлүүлэн төлбөрийн баримтын нэг хувийг өвчтний түүхэнд хавсаргана.
- 2.7 Төлбөртэй тусламж, үйлчилгээний /үр хөндөлт/ орлогын мэдээ, тооцоог нөхөн үржихүйн эрүүл мэндийн кабинетын сувилагч гаргаж, амбулаторийн эрхлэгчээр хянуулах, мөн өвдөлт намдаах эмчилгээний орлогын мэдээ, тооцоог эмэгтэйчүүдийн тасгийн мэдээгүйжүүлэгч сувилагч гаргаж, тасгийн эрхлэгчээр хянуулсны дараа байгууллагын захирлаар баталгаажуулж Захиргаа, санхүү, хүний нөөцийн албанд өгнө.

- 2.8 Ургийн эхо, ургийн гажиг, хэвлийн эхо хийж олсон орлогын 20 хувийг дүрс оношилгооны эмчид олгоно.
- 2.9 Төлбөртэй тусламж, үйлчилгээгээр /үр хөндөлт, өвдөлт намдаалт эмчилгээ/ олсон орлогын тодорхой хувийг холбогдох тооцооны үндсэн дээр тусламж үйлчилгээ үзүүлсэн эмч, эмнэлгийн ажилчдад дараах байдлаар урамшуулал болгон олгоно.
- 2.9.1 Гар соруурын аргаар үр хөндөлт /унтуулгатай/ хийж олсон орлогын 20 хувийг үр хөндөлт хийсэн эх барих эмэгтэйчүүдийн эмчид, ажилбарын үнийн дүнгийн 5 хувийг сувилагчид тус тус олгоно.
- 2.9.2 Гар соруурын аргаар үр хөндөлт хийх ажилбарын унтуулга хийж олсон орлогын орлогын 10 хувийг мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний эмчид, 5 хувийг мэдээгүйжүүлгийн сувилагчид тус тус олгоно.
- 2.9.3 10-12 долоо хоногтой жирэмсний үеийн үр хөндөлтийн эрсдэлийн ажилбар хийж олсон орлогын 20 хувийг үр хөндөлт хийсэн эх барих эмэгтэйчүүдийн эмчид олгоно.
- 2.9.4 Эмийн үр хөндөлт хийж олсон орлогын 20 хувийг үр хөндөлт хийсэн эх барих эмэгтэйчүүдийн эмчид, 5 хувийг эх баригч, сувилагчид тус тус олгоно.
- 2.9.5 Нугасны гадна хөндийн өвдөлт намдаах эмчилгээнээс олсон орлогын 10 хувийг мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний эмчид, 3 хувийг мэдээгүйжүүлэгч сувилагчид тус тус олгоно.
- 2.9.6 Уян дуран /унтуулгатай/ хийж олсон орлогын 15 хувийг эмчид, 10 хувийг мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний эмчид, 5 хувийг сувилагчид тус тус олгоно.
- 2.9.7 Уян дуран /унтуулгагүй/ хийж олсон орлогын 15 хувийг эмчид, 5 хувийг сувилагчид тус тус олгоно.
- 2.9.8 Маммографийн шинжилгээ хийж олсон орлогын 15 хувийг эмчид, 5 хувийг техникчид тус тус олгоно.

Гурав. Эрүүл мэндийн даатгалаар үйлчлэх тусламж, үйлчилгээний зохион байгуулалт, үйл ажиллагаа

- 3.1 Тус амаржих газарт зөвхөн эмэгтэйчүүдийн /жирэмсэнтэй холбоогүй/ өвчний учир амбулаторид тухайн сард хийгдсэн оношлогоо, шинжилгээг нэг бүлэг болгон, нэг тохиолдол хэмээн бүртгэнэ.
- 3.2 Оношилгоо, шинжилгээ хийлгэсэн даатгуулагчийн мэдээллийг даатгуулагч бүртэй хийсэн төлбөрийн тооцооны хамт Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт хүргэнэ.
- 3.3 Эрүүл мэндийн даатгалгүй иргэн эрүүл мэндийн даатгалаас санхүүждэг бүх төрлийн оношилгоо, шинжилгээ, эмчилгээний зардлыг өөрөө хариуцаж, төлбөрийг байгууллагын дансанд кассаар дамжуулан тушааж, мөнгө төлсөн баримтын нэг хувийг өөртөө авна.
- 3.4 Эрүүл мэндийн даатгалгүй иргэд болон тухайн жилд эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн дээд хязгаараас хэтэрсэн даатгуулагч өндөр өртөгт мэс заслын нэг удаагийн хэрэгслийн төлбөрийг өөрөө бүрэн хариуцна.
- 3.5 Даатгуулагч тушаалын дөрөвдүгээр хавсралтад заасан өндөр өртөгт эмнэлгийн хэрэгслийн төлбөрийг байгууллагын кассанд тушаана.
- 3.6 Амаржих газрын худалдан авах ажиллагааны журмаар нийлүүлэгдээгүй өндөр өртөгтэй зарим эмнэлгийн хэрэгслийг үйлчлүүлэгч өөрөө худалдан авна. Энэ тохиолдолд эмч үйлчлүүлэгчдэд урьдчилан танилцуулж, үйлчлүүлэгч зөвшөөрсөн байна.
- 3.7 Эрүүл мэндийн даатгалгүй иргэд өндөр өртөгтэй нэг удаагийн хэрэгслийн төлбөрийг өөрөө бүрэн хариуцан худалдан авах ажиллагааны үнийн дүнгээр кассанд тушаана.


Дөрөв. Хориглох заалт

- 4.1 Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.6-т "Жирэмсэн, төрөлт, төрсний дараах үетэй холбоотой эх барихын тусламж, үйлчилгээний зардал" заасан тусламж, үйлчилгээ авч буй иргэнээс төлбөр авахыг хориглоно.
- 4.2 Эрүүл мэндийн даатгалын сангаас оношлогоо, шинжилгээнд ногдож буй зардлыг даатгуулагчаас давхардуулан авахыг хориглоно.
- 4.3 Үйлчлүүлэгчдээс жагсаалтанд зааснаас бусад тусламж, үйлчилгээнд төлбөр авах, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд иргэдтэй шууд төлбөр тооцоо хийхийг хориглоно.
- 4.4 Ажлын байрандаа эм,бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, бусад материал хэрэгслийг худалдахыг хориглоно.
- 4.5 Иргэдээс немрөг, улавч, бие засах газар, өвчтөн шилжүүлэх болон шинжилгээний бичиг олгох, хувцас өлгөх зэрэг нийтлэг үйлчилгээнээс төлбөр авахыг хориглоно.

Тав. Журам зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлага

- 5.1 Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтан, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудад Хөдөлмөрийн тухай хууль, амаржих газрын хөдөлмөрийн дотоод журамд заасан арга хэмжээг авч, хохирлыг буруутай этгээдээр төлүүлнэ.

Нийслэлийн Өргөө амаржих газрын
даргын 2024 оны 09 дүгээр сарын 05 ний өдрийн
4/57 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ ТАРИФ

/төгрөг/

1. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ

№	Үйлчилгээний төрөл	Үнэ
Жирэмсний эрт үеийн үр хөндөлт		
1	10-12 долоо хоногтой жирэмсэний хугацаатай (Унтуулгатай)	75,000₮
2	9 ба түүнээс бага долоо хоногтой жирэмсэний хугацаатай (Унтуулгатай)	95,000₮
3	4-7 долоо хоногтой жирэмсэний хугацаатай (Унтуулгатай)	75,000₮
4	Эмийн үр хөндөлт	50,000₮
Жирэмснээс хамгаалах хэрэгсэл		
5	Ерөндөг авах	50,000₮
6	Ерөндөг авах (төвөгтэй, утасгүй)	120,000₮
7	Ерөндөг тавих (зэс)	50,000₮
8	Ерөндөг тавих (менгөжүүлсэн)	100,000₮
9	Жирэмснээс хамгаалах тарилга	40,000₮
10	Суулгац тавих	60,000₮
11	Суулгац авах	110,000₮
Сэргээн засах мэс засал		
12	Хярзан сэргээх мэс засал	300,000₮
Өвдөлт намдаах эмчилгээ		
13	Эпудрал (нугасны өвдөлт намдаалт)	60,000₮

2. ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАРИФ

№	Ангилал	Шинжилгээний төрөл	Үнэ
1	Нян судлал	Мөөгөнцөр илрүүлэх	28,000₮
2		Бичил биетэн өсгөвөрлөж, эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ (шарх, хамар, хамар залгиур, залгиур, чих, нүд, умайн хүзүү, шээсний сүв, үтрээ, өтгөн, идээ, буглаа, цэр, шээс, гуурсны арчдас (трахеостом, интубац, хэвлий, цээж, давсаг, ЭДВ-н болон бусад гуурс), хатгалтын шингэн, цэр бронхийн угаадасны нян судлалын шинжилгээ (хэвлий, плевр, тархи нугасны шингэн, үений шингэн, олгой цес)	32,000₮
3		Нян тээгчийн шинжилгээ	30,000₮
4		Шинжлэгдэхүүнийг будаж шинжлэх- Граммын будгийн арга	10,000₮
5		Цуснаас бичил биетэн өсгөвөрлөж, эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ	72,000₮
6		Шинжлэгдэхүүнийг будаж шинжлэх- Граммын будгийн арга	10,000₮
7		Цуснаас бичил биетэн өсгөвөрлөж, эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ	72,000₮
8		АЛАТ	3,000₮
9		Альбумин	3,000₮

10	Биохими	АСАТ	3,000₮
11		Билирубин нийт	3,000₮
12		Билирубин шууд	3,000₮
13		ГГТ Гаммаглутамилтрансфераза	3,000₮
14		Нийт уураг	6,000₮
15		Шүлтлэг фосфотаза	4,000₮
16		ЛДГ	4,000₮
17	Нойр булчирхайн үйл ажиллагааны шинжилгээ	Глюкоз	3,000₮
18		Нойр булчирхайн амилаза (П амилаза)	6,000₮
19		Амилаза	5,000₮
20		Липаза	6,000₮
21	Бөөрний үйл ажиллагаа	Креатинин	4,000₮
22		Мочевин	4,000₮
23		Шээсний хүчил (цус)	3,000₮
24	Эрдэс микроэлементийн шинжилгээ	Кали	5,000₮
25		Кальци	4,000₮
26		Магни	4,000₮
27		Натри	5,000₮
28		Үлдэгдэл азот	3,000₮
29		Фосфор	3,000₮
30		Хлор	5,000₮
31	Идээт үрэвсэлийн шинжилгээ	Төмөр	4,000₮
32		Лактат	5,000₮
33		Прокалцитонин (Procalcitonin)	85,000₮
34		С урвалжийн уураг (CRP) (тоогоор)	11,000₮
35	Өөх тосны солилцоо	Триглицерид	3,000₮
36		Холестерин	3,000₮
37		Липопротейн А	8,000₮
38		Их нягтралтай липопротеин	6,000₮
39	Үе мөчний шинжилгээ	Ревматоид фактор /RF/ (тоогоор)	9,000₮
40		С урвалжийн уураг (CRP) (тоогоор)	11,000₮
41		Антистрепитолизин O тест (ASLO /ASO) (тоогоор)	10,000₮
42	Цус багадалтын шинжилгээ	Трансферрин	9,000₮
43		Төмөр	4,000₮
44		Нугасны шингэнд хлор үзэх	5,000₮
45	Гематологийн шинжилгээ	Лейкограмм (захын цусны түрхэц)	20,000₮
46		УЭТХ (СОЭ)	4,500₮
47		Цусны дэлгэрэнгүй шинжилгээ	14,000₮
48	Иммуно гематологийн шинжилгээ	Цусны бүлэг, резус	11,000₮
49		Цусны резус бүлэг тодорхойлох (Rh фактор), баталгаажуулах	6,000₮
50		Цусны хувийн тохироо тодорхойлох	15,000₮
51		Эргэлзээтэй бүлэг тодорхойлох	9,000₮
52	Цус бүлэгнэлтийн шинжилгээ (коагулограмм)	АРТТ	5,000₮
53		D-Dimer	60,000₮
54		Fibrinogen	6,000₮
55		ТТ	5,000₮
56		PT (INR)	5,000₮

57	Шээсний ерөнхий шинжилгээ	Шээсний ерөнхий шинжилгээ	6,000₮
58		Шээсэнд глюкоз тодорхойлох	5,000₮
59	Иммунологийн шинжилгээ	Энгийн херпес вирус 1-ийн халдвар илрүүлэх (HSV 1 Ig G) ELISA	30,000₮
60		Энгийн херпес вирус 1-ийн халдвар илрүүлэх (HSV 1 Ig M) ELISA	30,000₮
61		Энгийн херпес вирус 2-ийн халдвар илрүүлэх (HSV 2 Ig G) ELISA	30,000₮
62		Энгийн херпес вирус 2-ийн халдвар илрүүлэх (HSV 2 Ig M)	30,000₮
63		Токсоплазм вирусийн архаг халдвар (Toxo IgG) электрохимолюминесценц	22,000₮
64		Токсоплазм вирусийн хурц халдвар (Toxo IgM) электрохимолюминесценц	22,000₮
65		Улаанууд вирусийн архаг халдвар (Rubella IgG) электрохимолюминесценц	23,000₮
66		Улаанууд вирусийн хурц халдвар (Rubella IgM) электрохимолюминесценц	23,000₮
67		Цитомегаловирус капсид уургийн эсрэг IgG электрохимолюминесценц	30,000₮
68		Цитомегаловирус капсид уургийн эсрэг IgM электрохимолюминесценц	30,000₮
69	Дааврын шинжилгээ	Прогестерон (Progesteron)	23,000₮
70		Прокалцитонин (Procalcitonin)	85,000₮
71		Пролактин (Prolactin)	23,000₮
72		Тестостерон (Testosteron)	24,000₮
73		17-OH Progesterone	30,000₮
74		Free estriol	30,000₮
75		PAPP-A	30,000₮
76		B вирусийн гадаргуугийн эсрэг бие (aHBs) электрохимолюминесценц	25,000₮
77		Витамин Д3 /25-оН/	36,000₮
78		Глюкозжсон гемоглобин	17,000₮
79		Хүний хорион гонадотропины даавар (HCG+b II)	22,000₮
80	Шар биеийг идэвхжүүлэгч даавар (LH)	20,000₮	
81	Эстрадиол (Estradiol)	21,000₮	
82	Бамбайн үйл ажиллагаа	Тиреод сэдээгч даавар (TSH)	17,000₮
83		Тироксин даавар (T4)	17,000₮
84		Триодтиронин даавар (T3)	15,000₮
85	Түргэвчилсэн шинжилгээ	ДОХ (HIV cassette)	6,000₮
86		Хепатитын B вирусийн гадаргуугийн эсрэг биеийн үзүүлэлт (HBsAg) cassette	6,000₮
87		Хепатитын C вирусийн эсрэг бие (anti-HCV) cassette	6,000₮
88		Хурдавчилсан ийлдсийн реаген тест (RPR)	8,000₮
89		Тэмбүү илрүүлэх өвөрмөц сорил (TPHA)	5,000₮
90	Молекул биологийн шинжилгээ	RT-PCR Папиллома вирус илрүүлэх-28 серотип	165,000₮
91		RT-PCR үндсэн 7 үүсгэгч (Trichomonas vaginalis, Mycoplasma hominis, Mycoplasma genitalium, Chlamydia trachomatis, Neisseria gonorrhoeae, Ureaplasma parvum, Ureaplasma urealyticum)	165,000₮
92		Ковид-19 (COVID-19 / SARS CoV-2) халдвар PHX илрүүлэх	35,000₮
93		Томуугийн А хэв шинжийн А (H1N1) pdm PHX илрүүлэх	110,000₮

94		Томуугийн В хэв шинж РНХ илрүүлэх	110,000₮
95	Хавдрын маркерын шинжилгээ	Өндгөвчний хавдрын маркер-CA 125-II	25,000₮
96		Хөхний хавдрын маркер (CA 15-3)	35,000₮
97		Элэгний хавдрын маркер (AFP)	20,000₮
98		Тархи нугасны шингэний ерөнхий шинжилгээ	30,000₮
99	Микроскопын шинжилгээ	Үтрээний наалдцын шинжилгээ	13,000₮
100		Шимэгч хорхойн өндөг илрүүлэг /натив харах/	5,000₮
101	Жирэмсэний хяналтын шинжилгээ	Пренатал илрүүлэг (Хоёрол тест)	120,000₮
102		Пренатал илрүүлэг (Гурвал тест)	120,000₮
103		Хүний хорин гонадотропины даавар (HCG+b II)	22,000₮
104		PAPP-A	30,000₮
105	Эд эсийн шинжилгээ	Цитологи шинжилгээ	10,000₮

3. ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Оношилгооны төрөл	Үнэ
1	Ургийн эхо	40,000₮
2	Ургийн гажгийн эхо	50,000₮
3	Хэвлийн эхо	40,000₮
4	Рентген/цээжний гэрэлд харах/	25,000₮
5	Бүх төрлийн рентген оношлогоо 1 байрлал (Гавал, хамар, цээж, хүзүү, ууц, нуруу, ахар сүүл, сээр, дээд мөч, доод мөч, аарцаг, аденойд, дал, өвчүү, ухархай, хавирга, чих, эгэм, эрүү)	20,000₮
6	Бүх төрлийн рентген оношлогоо 2 байрлал (Гавал, хамар, цээж, ууц, нуруу, ахар сүүл, сээр, дээд мөч, доод мөч, аарцаг, аденойд, дал, өвчүү, ухархай, хавирга, чих, эгэм, эрүү)	20,000₮
7	Кольпоскопия эсийн шинжилгээ	30,000₮
8	Кольпоскопия эдийн шинжилгээ	35,000₮
9	Уродинамикийн шинжилгээ	280,000₮
10	Гистеросальпингографийн шинжилгээ	200,000₮
11	12 сувгын холтер зүрхний цахилгаан бичлэг	80,000₮
12	Умайн хөндийн дуран	30,000₮
13	Умайн хүзүүний дуран (кольпоскопи)	30,000₮
14	Унтуулгатай уян дуран (бүдүүн гэдэс, уушги, улаан хоолой, ходоод төвөнх)	100,000₮
15	Уян дуран (бүдүүн гэдэс, уушги, улаан хоолой, ходоод төвөнх)	70,000₮
16	Маммографи (1 хөх 2 байрлал)	20,000₮
17	Маммографи (2 хөх 2 байрлал)	35,000₮
18	Рентген харалт (цээж хэвлий)	25,000₮
19	Ренген хяналтанд хийх ажилбар	60,000₮
20	Хоол боловсруулах замын баритай шинжилгээ(улаан хоолой, ходоод, дээд гэдэс, бүдүүн шулуун гэдэс)	60,000₮
21	Сэтгэлзүйн оношлогоо, сорил(бүх төрлийн гасанд хүрэгчдийн болон хүүхдийн сорилууд)	30,000₮
22	Хүүхдийн аутизмын оношилгоо	120,000₮
23	Төрсний дараах эхийн сэтгэлзүйн зөвлөгөө	65,000₮
24	Ургийн зүрхний бичлэг	15,000₮
25	Ургийн шингэнийг дурандах	20,000₮
26	Төрсний дараах эхийн сэтгэлзүйн зөвлөгөө	65,000₮
27	Рентген/цээжний гэрэлд харах/	25,000₮
28	Сүү оруулах зүү эмчилгээ	25,000₮
29	Голын хийн бариа	60,000₮
30	Стресс тайлах бариа	60,000₮
31	Бүтэн биеийн бариа	60,000₮

32	Хэсэгчилсэн бариа	35,000₮
33	Хануур	40,000₮
34	Шивүүр	40,000₮
35	Зүү эмчилгээ/нэг удаа/	9,000₮
36	Төөнүүр	8,000₮
37	УВЧ шарлага	5,000₮
38	ICT	5,000₮
39	Хэт ягаан туяа	5,000₮
40	Электрофорез	5,000₮
41	Шовх ургацагт үү авах	30,000₮

4. УРДЬЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛЭХ, ЗРҮҮЛ МЭНДИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ, ҮЗЛЭГ ЗӨВЛӨГӨӨ

№	Үйлчилгээний төрөл	Үнэ
1	Аж ахуй нэгж, байгууллагын захиалгаар зохион байгуулсан багцын урдьчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	Гэрээний үнийн дүнгээр
2	Гэр бүл болох, ажил суургуульд орох зорилгоор урдьчилан сэргийлэх, үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдах	150,000₮
Үйлчлүүлэгчийн хүсэлтээр үзүүлэх бусад нэмэлт тусламж үйлчилгээ		
3	Хөхний асаргаа, сувилгаа	20,000₮
4	Хөхөнд бүлээн жин тавих, массаж хийж хөхөлтөд бэлтгэх	20,000₮
5	Нярайг зөв амлуулж, зөв хөхүүлэх дадлага, зөвлөгөө	20,000₮
6	Нярайг усанд оруулах дадлага, зөвлөгөө	20,000₮
7	Нярайн массаж хийх дадлага, зөвлөгөө	20,000₮
8	Нярайг угжиж, сүү найруулах дадлага, зөвлөгөө	20,000₮
9	Нярайг хэхрүүлэх дадлага, зөвлөгөө	20,000₮
10	Нярайн хамар, нүд, чих цэвэрлэх дадлага, зөвлөгөө	20,000₮
11	Хөхний сүүг хадгалах зөвлөмж	20,000₮
12	Төрсний дараах асаргааны багц/бариа засал, сэтгэлзүйн зөвлөгөө, нярайн асаргаа/	240,000₮

Нийслэлийн Өргөө амаржих газрын
даргын 2024 оны 04 дүгээр сарын 30 ний өдрийн
А.С. /тоот тушаалын гуравдугаар хавсралт

НӨХЦӨЛ САЙЖРУУЛСАН ОРНЫ ТОО, МӨРДӨХ ТАРИФ

№	Эмчилгээний тасгийн нэр	Орны тоо	Нэг ор хоногийн төлбөр /төг/
1	Төрөх төрсний дараах тасаг		
1.1	Жирэмсний эмгэг эмчлэх хэсэг	3	30,000₮
1.2	Дутуу тээлтийг эмчлэх хэсэг	4	30,000₮
1.3	Төрөх хэсэг (люкс)	4	150,000₮
1.4	Төрсний дараах хэсэг	2	30,000₮
1.5	Төрөх өрөө	1	130,000₮
2	Нэгдсэн мэс засал, мэдээгүйжүүлгийн тасаг		
2.1	Мэс засал мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээ	1	30,000₮
3	Нярайн тасаг		
3.1	Нярайн эмгэгийг эмчлэх хэсэг	1	30,000₮
3.2	Нярайн (люкс)	2	70,000₮
4	Эмэгтэйчүүдийн тасаг		
4.1	Эмэгтэйчүүдийн тасаг	6	30,000₮